

МОНГОЛ УЛС ДАХЬ ОРОС, ХЯТАДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙ

*Б.Ганзориг**,
*Д.Начин***

Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалтын гадаад болоод дотоод эрх зүйн орчин үндсэндээ бүрдсэн юм.

Дэлхийн худалдааны байгууллагад 1997 онд, “Хөрөнгө оруулалтын талаар үүссэн маргааныг шийдвэрлэх тухай” Вашингтоны конвенцид 1996 онд, “Хөрөнгө оруулалтын даатгалын олон талт агентлаг байгуулах тухай” Сөүлийн конвенцид 1999 онд тус тус нэгдэн орсон ба Дэлхийн банкны Хөрөнгө оруулалтын олон талт даатгалын агентлагийн /MIGA/ гишүүн бөгөөд хөрөнгө оруулагчид MIGA-гийн эрсдлийн даатгалд хамрагдах эрхтэй. Монгол Улсын Засгийн газар Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих хоёр талын хэлэлцээрийг 39, Давхар татварын хэлэлцээрийг 34 улстай байгуулаад байна. Монгол Улсын хувьд Худалдааны гэрээ хэлэлцээрүүд, ялангуяа АНУ-тай байгуулсан Худалдаа, хөрөнгө оруулалтын ерөнхий хэлэлцээр, Европын Холбоотой байгуулсан худалдааны нэн тааламжтай гэрээ нь гадаадын хөрөнгө оруулалтыг татахад чухал нөлөөлөх үүрэгтэй, цаашид ч ийм гэрээ хэлэлцээрийг бусад улс орнуудтай байгуулагдах болно.

Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль (1990 онд анх баталж 1993, 1998 болон 2002 онуудад нэмэлт өөрчлөлтүүд оруулсан) нь гадаадын хөрөнгө оруулагчдад Монгол Улсын хуулиар хориглоогүй бизнесийн үйл ажиллагаа эрхлэх, гадаадын дагнасан аж ахуйн нэгж байгуулах зэрэг хөрөнгө оруулалтын чөлөөт горим олгож, хөрөнгө оруулалтыг хамгаалж, олсон ашиг орлогоо гуйвуулах зэрэг боломж олгодог. 2002 онд нэмэлт өөрчлөлт оруулсан Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулиар хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэх хэлбэр, төрлийг нэмэгдүүлснээс гадна томоохон хөрөнгө оруулагчдад татварын тогтвортой нөхцөлд ажиллах бололцоог нээж өгсөн.

Монгол Улсын төр, засгаас гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжихэд чиглэсэн тууштай бодлогын үр дүнд гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэж түүний нийгэм, эдийн засгийн үр нөлөө мэдэгдэхүйц болж ирлээ. 1995-1996 оны түвшинд жилдээ 30-40 орчим сая ам.долларын гадаадын хөрөнгө оруулалт бүртгэгдэж байсан бол

* Б.Ганзориг - Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлагийн дарга

** Д.Начин - мөн агентлагийн ажилтан

эдүгээ зөвхөн нэг жилд 200 гаруй сая ам.долларын хөрөнгө оруулалт орох болсон байна. Тухайлбал, 2004 онд 237 сая ам.долларын, 2005 онд 311 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийгдсэн байна. Өнөөдрийн байдлаар 1990 оноос хойш дэлхийн 88 орны 4800 гаруй гадаадын хөрөнгө оруулалттай компани нийт нэг тэрбум дөрвөн зуун сая гаруй ам.долларын шууд хөрөнгө оруулалт Монголд бүртгүүлсний 80 шахам хувь нь зөвхөн 2000-2005 онуудад хийгдсэн байна..

Гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО)-ыг үйлдвэрлэл, үйлчилгээний салбаруудаар авч үзвэл геологи хайгуул, уул уурхай, газрын тосны салбарт хамгийн их буюу нийт ГШХО-ын 47,7 хувь, худалдаа, нийтийн хоолны салбарт 15,4%, хөнгөн үйлдвэрт 6%, банк санхүүгийн үйл ажиллагаанд 5,3%, барилгын үйлдвэрлэлд 3,9%, малын гаралтай бүтээгдэхүүний боловсруулалтанд 3,8% орсон байна.

Хөрөнгө оруулагчдыг харьяалагдах улс орноор авч үзвэл БНХАУ-ын хөрөнгө оруулагчид Монголд орсон гадаадын хөрөнгө оруулалтын 47,4 хувиар хөрөнгө оруулагчдын жагсаалтыг тэргүүлж, Канад улс 12,2 хувиар удаалж, БНСУ (7,3%), Япон (5,0%), АНУ (3,6%), ОХУ (3,2%) болон бусад орны хөрөнгө оруулагчид дараагийн байруудад орж байна.

Уул уурхайн салбарт орсон гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ 2001 онд 60 сая ам.долларт, харин 2005 онд 191 сая ам.долларт хүрсэн бөгөөд нийт ГШХО-ын тал шахам хувь нь геологи хайгуул, уул уурхайн салбарт орсон учир 2001-2005 оныг уул уурхайн хөрөнгө оруулалтын жилүүд байлаа гэж дүгнэж болохоор байна.

Энэ салбарт оруулсан 686,8 сая ам.долларын хөрөнгө оруулалтын 52,5 хувийг БНХАУ-ын, 25,3 хувийг Канадын, 4,4 хувийг Болгарын, 3,1 хувийг АНУ-ын, 2,5 хувийг ОХУ-ын хөрөнгө оруулагчид үлдэх 12,2 хувийг Багамын арлууд, БНСУ, Виржинийн арлууд, Их Британийн зэрэг бусад орны хөрөнгө оруулагчид оруулсан байна.

Геологи хайгуул, уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулахаар бүртгүүлсэн компанийн тоо 1994 онд 7 байсан бол 1997 онд хамгийн их буюу 39, 2003 онд 29, 2004 онд 36, 2005 онд 25 болсон байхад хөрөнгө оруулалтын хэмжээ 1994 онд 1049 мянган ам.доллар, 1997 онд 17,5 сая ам.доллар, 2003 онд 158,3 сая ам.доллар, 2004 онд 146,7 сая ам.доллар, 2005 онд 191 сая ам.долларт хүрсэн байна.

Хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэхэд шинэ хөрөнгө оруулагчдаас гадна Монголд хөрөнгө оруулаад үйл ажиллагаа явуулж байгаа хөрөнгө оруулагчид дахин хөрөнгө оруулж байгаа нь Монголд хөрөнгө оруулж

бизнес эрхлэх муугүй нөхцөл байгааг давхар нотолж байгаа хэрэг бөгөөд үүнийг ч олон улсын байгууллагаас давхар нотолж байгаа юм.

НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал (UNCTAD)-аас дэлхийн 140 орны гадаадын хөрөнгө оруулалт шингээх чадварыг үнэлэхэд Монгол Улс энэ үзүүлэлтээр харьцангуй их хөрөнгө оруулалт татаж чадсан, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах харьцангуй өндөр чадавхитай орнуудын жагсаалтанд багтаах болсон байна.

Монгол Улс, ОХУ-ын хооронд он дамнан яригдсаар ирсэн “их өрийн” асуудлыг 2003 онд эцэслэн шийдвэрлэснээр олон улсын зэрэглэл тогтоох Фич, Мүүдиз, Стандарт энд Пүүрс байгууллагуудаас манай орны зээлжих зэрэглэлийг +В болгон дээшлүүлэх нөхцлийг бүрдүүлэн гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд нааштай нөлөө үзүүлж байна.

Монгол Улсын Засгийн газар нь ОХУ-ын Засгийн газартай 1995 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр “Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах хоёр талт хэлэлцээр”-г, 1995 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр “Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай” гэрээнд гарын үсэг зурсан бөгөөд давхар татварын гэрээ нь 1998 оны 1 дүгээр сараас хүчин төгөлдөр болсон.

ОХУ-ын бизнес эрхлэгчид 1991 оноос Монголд хөрөнгө оруулалт хийж эхлэсэн бөгөөд 1993 оноос 261 мянган ам.долларын, дараа дараагийн жилүүдээс энэ тоо хэмжээ өсөн нэмэгдэж 2001 онд 5.7 сая ам.доллар, 2005 онд 8,7 сая ам.долларт хүрсэн байна. ОХУ-ын хөрөнгө оруулагчдаас Монголд хөрөнгө оруулах сонирхол өсөн нэмэгдэж байгааг үйл ажиллагаа явуулахаар бүртгүүлсэн компанийн тооноос харж болох юм. Тухайлбал, 1991 онд 5 компани, 1993 онд 9 компани бүртгүүлж байсан бол 1997 онд 33, 2004 онд 45, 2005 онд 59, нийтдээ 502 компани бүртгүүлсэн байна. ОХУ-ын хөрөнгө оруулагчид Монголд нийтдээ 45 сая гаруй ам.долларын хөрөнгө оруулсан нь Монголд орсон нийт гадаадын хөрөнгө оруулалтын 3 орчим хувийг бүрдүүлж байна. (Энд 1990 оноос өмнөх гадаадын хөрөнгө оруулалтыг оруулаагүй болохыг анхаарна уу.)

ОХУ нь бүртгэгдсэн хөрөнгө оруулалтын хэмжээгээрээ 6 дугаарт /45,8 сая ам.доллар/, компанийн тоогоороо 3 дугаарт /502/ орж байна. ОХУ-аас уул уурхай /17 сая ам.доллар/, барилга байгууламж, барилгын материалын үйлдвэрлэл /5.3 сая ам.доллар/, банк санхүү /4.1 сая ам.доллар/ (Чингис хаан банк), хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл /4,1 сая ам.доллар/-ийн салбаруудад түлхүү хөрөнгө оруулалт хийгдсэн байна. Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн салбарын нийт хөрөнгө

оруулалтын 26,4 хувийг эзлэж байна. Барилга байгууламж, барилгын материалын үйлдвэрлэлийн салбарт ч мөн адил томоохон хөрөнгө оруулагч бөгөөд салбарын хөрөнгө оруулалтын 9,5 хувийг оруулсан байна. 2005 оны хувьд хөрөнгө оруулалтын хэмжээ 2004 оныхтой харьцуулахад эрс нэмэгдэж 8,6 сая ам.долларт хүрсэн байна.

Энэ бүгдээс үзэхэд ОХУ-ын хөрөнгө оруулалт өсөн нэмэгдэж, тэр нь бодитой зүйл болон Монголын нийгэм, эдийн засгийн хөгжилд өөрийн зохих хувь нэмрээ оруулж байна гэж хэлж болохоор байгаа боловч эдний дотор манай улсын эдийн засагт дорвитой хувь нэмэр оруулах томоохон хөрөнгө оруулалттай компани одоогийн байдлаар байхгүй байна гэж зарим судлаачид үзэж байна. Энэ дашрамд 1970-аад онд байгуулагдсан МонСовЦветМет (хуучин нэрээр), 1973 онд байгуулагдсан Эрдэнэт уулын баяжуулах үйлдвэрүүд нь одоогийн мөрдөж байгаа Гадаадын хөрөнгө оруулалтын хуулийн дагуу 2003 оноос гадаадын хөрөнгө оруулалттай компани болон ажиллаж байгаа болохыг тэмдэглэх нь зүйтэй юм. ОХУ-ын хөрөнгө оруулалттай компаниудаас 2000-2003 онуудад 100 мянган ам. доллараас дээш хөрөнгө нэмж оруулсан 9 компани байгаа бөгөөд эдгээрээс Монсиб алт, Буянтгаз, Алтан хөндий компаниуд Геологи хайгуул, уул уурхай, газрын тосны салбарт, Саймос, Мемомонголиа компаниуд мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлд үйл ажиллагаа явуулахаар дахин хөрөнгө оруулсан байна.

Геологи хайгуул, уул уурхай, газрын тосны салбарт ийнхүү ихээхэн хэмжээний хөрөнгө дахин оруулах болсон нь Монгол Улсын Засгийн газраас энэ чиглэлд авч хэрэгжүүлсэн тодорхой алхмууд, тухайлбал, Гадаадын хөрөнгө оруулах тэргүүлэх чиглэлийн жагсаалтыг 2001 онд, “Геологи, уул уурхайн салбарын талаар ойрын жилүүдэд баримтлах чиглэл”, “Монгол Улсын эрчим хүчний тогтвортой хөгжлийн 2002-2010 оны стратеги төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл” зэргийг 2002 онд баталсантай холбоотой гэж үзэж байна.

Энд гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд манайд нааштайгаар нөлөөлж байгаа нэгэн шинэ хүчин зүйл бол Европ, Америк төвтэй дэлхийн уламжлалт зах зээл Ази, тэр дундаа БНХАУ руу чиглэн шилжиж байгаа явдал юм. БНХАУ нь ДХБ-д гишүүнээр элсэж орохдоо аж үйлдвэрийн бараа, бүтээгдэхүүний импортын тарифыг 24.6 хувиас дунджаар 9.4 хувь хүртэл бууруулж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний импортын тарифыг 31.5 хувиас 17.4 хувь хүртэл бууруулахаар авсан үүрэг амлалт, эдийн засгийн өсөлттэй уялдаж БНХАУ-ын импорт нэмэгдсээр байна. Иймд энэхүү асар том зах зээлийг бараадан дөхөх үүднээс гадаадын

хөрөнгө оруулагчдад эдийн засгийн либерал бодлого, тогтолцоотой Монголыг сонирхох нь ирээдүйдээ үр ашигтай байх үндэслэлтэй юм.

Хятад улс нь 2004 онд 61 тэрбум ам.долларын буюу хамгийн их гадаадын хөрөнгө оруулалт татаж чадсан орон (UNCTAD 2005) гэж тооцогдож байгаагаас гадна сүүлийн жилүүдэд гадагшаа хөрөнгө гаргаж эхлэсэн байна. Үүнийг Монголд оруулж байгаа Хятадын хөрөнгө оруулалтын байдлаас харж болно. Хятадын хөрөнгө оруулагчид Монголд нийтдээ 682 сая гаруй ам.долларын хөрөнгө оруулсан нь Монголд орсон нийт гадаадын хөрөнгө оруулалтын 47 хувийг бүрдүүлж байна.

Монгол Улсын Засгийн газар нь БНХАУ-ын Засгийн газартай 1991 оны 8 дугаар сарын 26-ны өдөр “Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах хоёр талт хэлэлцээр”, “Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай” гэрээнд гарын үсэг зурсан бөгөөд эдгээр нь 1993 оны 1 дүгээр сараас хүчин төгөлдөр болсон.

Хятадын бизнес эрхлэгчид 1990 оноос Монголд хөрөнгө оруулалт хийж эхлэсэн бөгөөд Монгол Улсад оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ болон хөрөнгө оруулалттай компаний тоогоороо аль алиар нь тэргүүлж буй орон. БНХАУ-ын хөрөнгө оруулагчид геологи уул уурхайн судалгаа, эрэл хайгуул, олборлолт /360 сая ам.доллар/, худалдаа, нийтийн хоол /151 сая ам.доллар/ инженерийн барилга байгууламж, барилгын материалын үйлдвэрлэл /29 сая ам.доллар/, хөнгөн үйлдвэр /23 сая ам.доллар/-ийн салбарт түлхүү хөрөнгө оруулалт хийгээд байгаа билээ.

Хятадын хөрөнгө оруулагчдаас Монголд хөрөнгө оруулах сонирхол өсөн нэмэгдэж байгааг үйл ажиллагаа явуулахаар бүртгүүлсэн компанийн тооноос харж болох юм. Тухайлбал, 1990 онд 1 компани, 1993 онд 12 компани бүртгүүлж байсан бол 1997 онд 73, 2002 онд 161, 2005 онд 579, нийтдээ 2177 компани бүртгүүлсэн байна.

Эдгээрээс Эс энд Ти голд, Төмөртэй хүдэр, Доншен газрын тос монгол, Баолинпетрохим зэрэг компани геологи, уул уурхай, газрын тосны эрэл, хайгуул, судалгаа, олборлолтын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа болно.

Дүгнэлт

- Монгол Улсын төр, засгаас гадаадын хөрөнгө оруулалтын талаар баримталсан тууштай бодлого, төрийн захиргааны байгууллагуудаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд, бизнес

эрхлэгчдийн олон жилийн хамтын чармайлтын үр дүнд Монгол Улсад орох гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ өсөн нэмэгдсэн бөгөөд НҮБ-ын Худалдаа, Хөгжлийн Бага хурал – UNCTAD-аас нийгэм, эдийн засгийн тодорхой үзүүлэлтүүдээр улс орнуудын гадаадын шууд хөрөнгө оруулалтыг хүлээн авч байгаа байдал болон тухайн оронд гадаадын шууд хөрөнгө оруулах чадавхийг судалж дэлхийн 140 орныг жагсаахад Монгол Улс нь гадаадын шууд хөрөнгө оруулалтын харьцангуй өндөр чадавхи, үзүүлэлт бүхий орнуудын тоонд багтах болсон.

- Гадаадын хөрөнгө оруулалт өсөн нэмэгдэхэд гадаадын хөрөнгө оруулалтыг татах сурталчилгааг эрчимтэй, тодорхой чиглэлтэй зохион байгуулж байсан нь тодорхой нөлөө үзүүлсэн бөгөөд эдүгээ Монголд 88 орны (эдгээрийн 37 улстай хөрөнгө оруулалтыг харилцан хамгаалах, хөхиүлэн дэмжих тухай хоёр талын гэрээ байгуулсан) хөрөнгө оруулагчдын эдийн засгийн ямар нэгэн сонирхол эдүгээ Монголд бий болоод байгаагаас гадна хоёр хөрш орны хөрөнгө оруулалтыг тэнцвэржүүлэх, гурав дахь хөршийн оролцоог нэмэгдүүлэн хөгжүүлэх шаардлагатай байгаа нь харагдаж байна.

- 2006 онд болон түүнээс цааших хугацаанд Монгол Улсад орох гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэнэ гэсэн төсөөлөлтэй байгаа бөгөөд үүнийг уул уурхайн олон улсын компаниудын геологи хайгуулын идэвхитэй үйл ажиллагаа, Олон Улсын Санхүүгийн корпорациас зарим арилжааны банкинд хөрөнгө оруулсан, аялал жуулчлалын салбарын хөгжил, Европын Холбооноос GSP+ нөхцлийн хүрээнд 7200 орчим нэр төрлийн бараа бүтээгдэхүүнийг татваргүйгээр Европын холбооны орнуудын зах зээлд оруулах шийдвэрт Монгол Улсыг хамруулсан зэрэгтэй холбож байна. Мөн түүнчлэн Эдийн засгийн чөлөөт бүсүүд, Бүсчилсэн хөгжлийн бүсүүдэд ГШХО-ыг татах эрх зүйн орчин, боломжууд бүрэлдсэн, Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 5 дугаар сард Засгийн газрын тогтоолоор 40000 орон сууц хөтөлбөр баталж Улсын Их Хурлаас “Зарим материал, тоног төхөөрөмж, машин механизмыг гаалийн албан татвараас чөлөөлөх тухай” болон “Зарим материал, машин механизм, тоног төхөөрөмж, бараа, ажил үйлчилгээг нэмэгдсэн өртөгийн албан татвараас чөлөөлөх тухай” хуулийг баталсан зэрэг нь гадаадын хөрөнгө оруулалтыг татах нөхцөл боллоо гэж үзэж байна.

Ашигласан хэвлэл

1. Үндэсний Статистикийн Газар, (ҮСГ), 2005, Монгол Улсын Статистикийн Эмхтгэл 2004, Улаанбаатар: ҮСГ.
2. Монгол Улсын Засгийн Газар (МУЗГ), 2002, Төрийн Мэдээлэл 2002, # 5, Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын хууль.
3. Монгол Улсын Засгийн Газар (МУЗГ), 2001, Төрийн Мэдээлэл 2001, # 7, Гадаадын хөрөнгө оруулах тэргүүлэх чиглэлийн жагсаалт батлах тухай Засгийн Газрын тогтоол N140.
4. Монгол Улсын Засгийн Газар (МУЗГ), 2005, Төрийн Мэдээлэл 2005, #11, Сүлжмэл эдлэл, оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн тогтвортой ажиллагааг хангах зарим арга хэмжээний тухай Засгийн Газрын тогтоол N32, 2005 оны 3 дугаар сарын 2-ны өдөр.
5. Монгол Улсын Засгийн Газар (МУЗГ), 2005, Төрийн Мэдээлэл 2005, # 32, 40 000 орон сууц хөтөлбөр батлах тухай Засгийн Газрын тогтоол N144, 2005 оны 6 дугаар сарын 27-ны өдөр.
6. United Nations Conference on Trade and Development, 2002, World Investment Report 2002: Transnational Corporations and Export Competitiveness, United Nations, New York and Geneva, 2002
7. United Nations Conference on Trade and Development, 2003, World Investment Report 2003: FDI Policies for Development: National and International Perspectives, United Nations, New York and Geneva, 2003
8. United Nations Conference on Trade and Development, 2004, World Investment Report 2004: The Shift Towards Services, United Nations, New York and Geneva, 2004
9. United Nations Conference on Trade and Development, 2005, World Investment Report 2005: Transnational Corporations and the Internationalization of R&D, United Nations, New York and Geneva, 2005